

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН БЭГЗЖАВ ОВОГТОЙ ЯНЖМААГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн асуудал болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх асуудлыг бодлого төлөвлөлтөд тусгах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах”							
1.	Арга хэмжээ 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийг шинэчлэн боловсруулж холбогдох яамдаас санал авах	Дүрмийн төслийг шинэчлэн боловсруулсан байна.	-	100%	Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан комиссын дүрэмд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган шинэчлэн боловсруулж байна. Үүнтэй холбоотойгоор 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр аймаг дүүргийн салбар комиссын нарийн бичгүүдтэй цахим уулзалт, 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийн төслийг танилцуулах, төрийн болон төрийн бус байгууллагын саналыг тусгах хэлэлцүүлгийн холбогдох төрийн	10-12	70%

					болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 26 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа. Дүрмийн төсөлд холбогдох төрийн байгууллагын төлөөлөл, төрийн бус байгууллага, салбар комиссын гишүүдийн саналыг цахим шуудангаар хүлээн авч тусган боловсруулав.		
Зорилт 2. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
2.1 “Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт болон үнэлгээний арга аргачлал, хөгжлийн дэмжлэгийн хөтөлбөр, шаардлагатай дүрэм, журам, стандарт боловсруулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих”							
2.	Арга хэмжээ 2.1.1 Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Мэдээллийн нэгдсэн сан”-г салбар комиссын хэрэгцээнд хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээллийн сан ашиглах журмыг батлуулах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100%	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг WWW.CWD.MLSP.GOV.MN Домэйн нэрээр төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” болон E-Mongolia системтэй холбож, дүүргүүдийн салбар комиссын нарийн бичиг нарт нэвтрэх эрх үүсгэн салбар комиссын ээлжит хуралд туршин ашиглаж эхэлсэн. Одоогийн байдлаар мэдээллийн санг бүрэн ашиглахад хүүхдийн мэдээлэл дуудаж байгаа хурд муу байгаа учир сайжруулах шаардлагатай байгаа. Мэдээллийн санг бүрэн ашиглалтад оруулснаар дараах ач холбогдолтой. Үүнд: - Салбар комиссын ээлжит хурал, кейс хэлэлцүүлгийн мэдээллийг оруулж, тайлан хэвлэх боломжтой. - Хүүхдүүдийн мэдээллийг санд нэгтгэх боломжтой. - Төрийн мэдээлэл солилцооны системүүдээс зорилтот хүүхдийн үндсэн мэдээллийг татах боломжтой.	03-12	70%

					- Сургалтын видео лекцүүдийг байршуулсан бөгөөд сургалтад тогтмол ашиглах боломжтой. Мөн мэдээллийн сангийн ашиглах журмын төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.		
3.	Арга хэмжээ 2.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Хөгжлийн дэвтэр”-ийг сайдын тушаалаар батлуулан ХБХЭМБНХ-ын комиссын үйл ажиллагаанд ашиглах ажлыг зохион байгуулах	Хөгжлийн дэвтэрийг ашиглах	-	100%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлалд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн дэвтрийн загварыг боловсруулан 2024 оны 06 дугаар сарын 26-ны А/131 тоот сайдын тушаалаар батлуулж Жайка олон улсын байгууллагын “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төслийн багт хүргүүлэн 3000 ширхэгийг хэвлүүлэн хүлээн авсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цахим Мэдээллийн сан бүрэн ашиглалтанд орж салбар комиссын гишүүдийн гараар тэмдэглэн бичих ачаалал багасах үед буюу 2025 оны 1 дүгээр сард салбар комиссуудад хүргүүлэн үйл ажиллагаанд ашиглах бэлтгэлийг хангасан.	01-08	80%
2.2. “Аймаг, дүүргийн Салбар комиссын гишүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж , заавар, зөвлөмж, үйл ажиллагааны чиглэл өгөх, хяналт тавих”							
4.	Арга хэмжээ 2.2.1. Нийслэлийн 9 дүүргийн салбар комиссын үйл ажиллагаанд явцын хяналт хийх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100%	2024 оны эхний хагас жилд Баянгол дүүрэг, Чингэлтэй дүүргүүдийн салбар комиссын хуралд, 2024 оны 10 дугаар сард Чингэлтэй, Баянзүрх, Хан-уул, Сонгинохайрхан дүүргүүдийн хуралд биечлэн оролцож хурлын зохион байгуулалт, хувийн хэргийн ашиглалт, хадгалалт болон холбогдох бичиг баримтуудад төлөвлөгөөний дагуу хяналт хийж, зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн нийслэлийн 9 дүүргээс улирал бүр ирүүлж байгаа тайланд бичиг баримтын хяналтыг хийж	02-12	80%

					гарсан алдаа дутагдлыг тухай бүр холбогдон залруулж сайжруулан ажиллалаа. Хяналтаар: - Салбар комиссууд хурал зохион байгуулах тогтсон өрөө тасалгаагүйгээс хүүхдүүдийн хувийн хэргийн хадгалалтын аюулгүй байдал хангагдаагүй - Комиссын гишүүдийн хурлын явцад хийх ажил үүргийн хувиарлалтыг тодорхой хийгээгүйгээс зарим гишүүдийн оролцоо сул, зарим гишүүд хэт ачаалал ихтэй байх - Маягтыг зааврын дагуу хөтлөхгүйгээр дутуу бөглөх - Комиссын гишүүдийн ирц бүрэн бус байх үед хурлыг зохион байгуулах зэрэг асуудлууд гарсан. Дээрх гарсан зөрчлүүдийг арилгаж комиссын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр албан бичиг хүргүүлсэн.		
5.	Арга хэмжээ 2.2.2. Салбар комиссуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, зөвлөмж, чиглэл хүргүүлэх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дарга нарт 2024.02.14-ны өдрийн 03/393, 2024.06.07-ны өдрийн 10/1696 тоот албан бичгээр ажил сайжруулах тухай болон шаардлагатай чиглэлүүдийг тус тус хүргүүлсэн. 2024 оны байдлаар нийслэлийн 6 дүүргийн салбар комиссын гишүүдтэй 2 удаагийн уулзалт, 21 аймаг 9 дүүргийн салбар комиссын нарийн бичгийн дарга нартай 2 удаагийн онлайн сургалтыг тус тус хийсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоотой хамтран “Төрийн байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуус эрхээ эдлэх нь” сургалтанд салбар комиссын 112 гишүүн, хамрагдсан. Мөн салбар	02-12	80%

6.					комиссын гишүүдийг шаардлагатай мэдээ мэдээллээр тухай бүр ханган ажиллаж байна.		
	Арга хэмжээ 2.2.3. Салбар комиссуудын улирлын тайланг хуваарийн дагуу хүлээн авч, нэгтгэх, комиссын гишүүдийн урамшууллын тооцооллыг хийх, тушаал төлөвлөх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100%	Салбар комиссын гишүүдийн урамшууллыг улирал бүрийн тайланг нэгэтгэн олгож байгаа бөгөөд 2024 онд 30 салбар комисс нийт 610 удаагийн хурал зохион байгуулж 10,512 хүүхдийн асуудлыг хэлэлцсэн байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлсон 4064, хөгжлийн бэрхшээлгүйг тодорхойлсон 229, байнгын асаргаанд шинээр хамруулсан 2354, байнгын асаргаа шаардлагатайг сунгасан 6123, байнгын асаргааг цуцалсан 630, эрүүл мэндийн үйлчилгээнд 3544, боловсролын үйлчилгээнд 3016 хүүхдийг хамруулан ажилласан байна. Салбар комиссын гишүүдийн хуралдсан цаг, хурлаар орсон хүүхдийн тоог харьцуулан тооцож урамшууллыг олгосон бөгөөд 1 дүгээр улиралд 58,527,516 төгрөг, 2 дугаар улиралд 59,120,401 төгрөг, 3 дугаар улиралд 63,768,852 төгрөг, 4 дүгээр улиралд 58,799,050 төгрөг нийт 240,215,821 төгрөгийг олгосон байна.	04-12	930%
7.	Арга хэмжээ 2.2.4 Салбар комиссуудаас байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гаргуулан авч, нэгтгэл хийх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь		100%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын салбар комиссуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 14,609 хүүхдийн судалгааг нас, хүйс, бэрхшээлийн төрөл хэлбэр, шаардлагатай онцлог хэрэгцээ, боловсролын үйлчилгээний чиглэлээр нарийвчлан гаргаж нэгтгэлээ. Судалгаагаар улсын хэмжээнд 14,609 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 13,077 харааны бэрхшээлтэй 713, сонсгол хэл ярианы бэрхшээлтэй 894, хөдөлгөөний 977, оюун сэтгэцийн 1395, аутизм 2395, даун 663, уналт таталт 1140,	10-11	90%

					тархины саа саажилт 2275, мэс заслын дараах 390, хавсарсан болон бусад бэрхшээлтэй 1935 хүүхдүүд байна. Мөн хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хэвтрийн 1694, гэрийн асрамж халамж дутагдалтай хүүхэд 445 байна. Дээрх тоон судалгаанд тулгуурлан байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нийгмийн халамжийн сангаас олгож буй амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 30 хувиар нэмэгдүүлэх хүнд хэлбэрийн хүүхдүүдийг тодорхойлох, тогтмол памперсны хэрэглээтэй хүүхдийг тодорхойлж улирал бүр памперсны мөнгө олгох хөнгөлөлтөнд хамруулах, тогтмол танхимын сургалтанд хамрагдах боломжгүй хүүхдүүдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх дэмжих төвийн үйлчилгээнд хамрагдах хүүхдийг тодорхойлох ажлууд хийгдэх юм.		
8.	Арга хэмжээ 2.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүд, холбогдох хүний нөөцийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийн чадавхийг сайжруулах чиглэлээр 2024 онд цахим сургалт 2 удаа зохион байгууллаа. Мөн цахим мэдээллийн санд Жайка олон улсын байгууллагын төслийн багтай хамтран дараах сэдвээр видео хичээлүүдийг бэлтгэн байршуулсан. Үүнд: - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал - Байнгын асаргааны өвчин гэмтлийн жагсаалт - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах тогтолцоо - Кейс хэлэлцүүлэг - Оюуны бэрхшээлийн онцлог ба ажиллах арга зүй - Тулгуур эрхтний бэрхшээлийн онцлог ба ажиллах арга	10-11	80%

					- Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй - Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй Мөн Японы Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа “Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийг хөгжлийг дэмжих нь” төсөлтэй хамтран төслийн зорилтот орон нутгуудын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтыг 10 дугаар сарын 8,9 өдрүүдэд Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд 10 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт 10 дугаар сарын 30-ны өдөр Баянхонгор аймагт тус тус зохион байгууллаа. Тус сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, комиссын дүрэм, кейс хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй, хөгжлийн бэрхшээл, түүний онцлог, эрт илрүүлэг зэрэг сэдвүүдээр хичээл орж оролцогдын сургалтын өмнөх болон дараах мэдлэгийн түвшинг тодорхойлж харьцуулалт хийлээ.		
2.3. “Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх”							
9.	Арга хэмжээ 2.3.1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас тус улсын “Жайпур фүүт” хүмүүнлэгийн байгууллагаар дамжуулан Монгол Улсын хөгжлийн	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас тус улсын “Жайпур фүүт” хүмүүнлэгийн байгууллагаар дамжуулан Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй 600 иргэнд буцалтгүй тусламжаар гар, хөлийн протез хийх ажлыг зохион байгуулахаар тус улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам болон Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хооронд Хамтран ажиллах тухай баримт бичигт гарын үсэг зурсан. Үүний хүрээнд Хөдөлмөр, нийгмийн	06-11	90%

	бэрхшээлтэй иргэдэд буцалтгүй тусламжаар гар, хөлийн протез хийх ажилд хамтран ажиллах				хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/52 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж, тус ажлын хэсэгт орж ажилласан. Хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулах байр, талбайг бэлтгэх, Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас ирэх эмч, эмнэлгийн ажилтнуудын визний асуудлыг шийдвэрлэх зэрэг бэлтгэл ажлыг бүрэн хангуулах ажилд хамтран ажиллалаа.		
10.	Арга хэмжээ 2.3.3 “Оюуны бэрхшээлтэй хүүхдийг биеийн тамир спортоор дамжуулан нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэх “Хамтарсан сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			Оюуны бэрхшээлтэй хүүхдийг биеийн тамир, спортоор дамжуулан хөгжүүлэхэд их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, тусгай сургууль, цэцэрлэгүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, мөн хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах зорилго бүхий “Хамтарсан сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг 2024 оны 04 сарын 02-ны өдрийн А/63 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 4 дүгээр сарын 15, 5 дугаар сарын 02 өдрүүдэд 2 удаа зохион байгуулсан. Мөн 5 дугаар сарын 28-ны өдөр хөтөлбөрт хамрагдах сургуулийн удирдлагууд болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүдэд хамтарсан сургууль хөтөлбөрийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан. Хамтарсан сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 140,000,000 төгрөгийн төсвийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас олгосон бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж арга зүйн зөвлөмж үзүүлэн ажиллалаа.	06-09	70%

2.4. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар хамтран ажиллах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах

11.	Арга хэмжээ 2.4.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх “Дэмжих төв”-ийн ажлын хэсэгт ажиллаж шаардлагатай ажлуудыг зохион байгуулах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			Боловсролын ерөнхий хуулийн 17.9-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрмийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны зүгээс дүрмийн төсөлд тусгах санал, арга хэмжээг боловсруулан Боловсролын яаманд хүргүүлсэн. Мөн 2025 онд Дэмжих төвийг санхүүжүүлэн ажиллах чиглэлийн дагуу дэмжих төвийн үйлчилгээ үзүүлэх журам, стандарт, шаардлагатай бичиг баримтыг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/154 тоот тушаалаар байгуулан шаардлагатай судалгаа мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. Мөн дэмжих төвөөр үйлчлүүлэх хүүхдүүдийн үнэлгээний аргачлалын төслийн боловсруулан батлуулах бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.	04-12	70%
12.	Арга хэмжээ 2.4.2 Тусгай хэрэгцээт хүүхдэд шаардлагатай эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь төслийн хүрээнд Жайка старт 2 төсөлтэй хамтран ажиллах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			Жайка олон улсын байгууллагын Старт 2 төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах асуудлуудын хүрээнд хамтран ажиллалаа. Үүнд: - Салбар комиссын нарийн бичгийн даргын орон тоог бий болгох талаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн бүтэц орон тоонд Хүүхдийн сэргээн засах багт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын арга зүйч” ажиллана	01-12	90%

				гэж заасан. Одоогийн байдлаар Дорнод, Ховд, Дархан-уул, Хөвсгөл, Архангай, Дунд-говь аймгууд орон тооны нарийн бичигтэйгээр ажиллаж байна. - Салбар комиссоос кейс хэлэлцүүлэг зохион байгуулахад олгох төсвийг шийдэх Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг дүүргүүдийн Засаг даргын хооронд төрийн чиг үүргийг 2024 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд дараах заалтуудыг тусгасан. Үүнд: ✓ Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дүрэмд заасан аймаг дүүргийн Засаг даргын чиг үүргийг хэрэгжүүлж харьяа орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж салбар комиссын гишүүдийг чадавхжуулна ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, шинжлэх ухаан, Эрүүл мэндийн сайдын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх, аргачлал, маягт шинэчлэн батлах тухай” 2021 оны А/220/475/812 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлж, харьяа аймаг, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлнэ.		
--	--	--	--	--	--	--

				Эдгээр заалтуудыг тусгасан бөгөөд салбар комиссын үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 20 сая хүртэлх төгрөгийн санхүүжилтыг зарцуулахаар төсөвлөн ажиллаж байна. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн боловсролын үйлчилгээг сайжруулах чиглэлээр БШУЯ-тай хамтран ажиллах Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор үзүүлэх тусгай чиг үүргийн байгууллага бөгөөд тус төвөөр үйлчлүүлж байгаа тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг чанартай үзүүлэхэд шаардлагатай ном сурах бичиг, туслах хэрэглэгдэхүүн болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн хамтран ажиллах хүсэлтийг Боловсролын яаманд 2024 оны 04 сарын 23-ны өдрийг 01/156 тоот албан бичгээр хүргүүлсэн. Боловсролын яамны 2024 оны 05 сарын 07-ны өдрийн 5/1879 тоот албан бичгээр Боловсролын ерөнхий хуульд заасан “Дэмжих төв”-ийн дүрмийг боловсруулан ажиллаж байгаа талаар болон тус төвийн дүрмийг батласнаар чиг үүргийн хүрээнд хүрээнд хамтран ажиллах боломжтой талаар хариу ирүүлсэн. Төслийн хүрээнд Салбар комиссын үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн санг ашиглалтанд оруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжих үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын мэдээллийг шинэчлэх ажлуудад арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй		
--	--	--	--	---	--	--

					хүүхдийн хөгжлийн дэвтрийн эхийг бэлтгэн 3000 ширхэгийг хэвлүүлэн ашиглах бэлтгэл ажлыг хангаж ажилласан. 2024 оны 05 дугаар сарын 14, 22-ны өдрүүдэд төслийн хамтарсан зохицуулах хорооны хуралд манай яамтай хамтран хэрэгжүүлсэн зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгэтгэн танилцуулсан бөгөөд төсөл дууссантай холбогдуулан шаардлагатай мэдээ мэдээлэл, тайланг нэгтгэн хүргүүлсэн.		
13.	Арга хэмжээ 2.4.3 Хүүхдийг ивээх сан “Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийг хөгжлийг дэмжих нь” төсөлтэй хамтран ажиллах, шаардлагатай арга хэмжээнд оролцох	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			“Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийг хөгжлийг дэмжих нь” төслийн 4 дүгээр бүрэлдэхүүн хэсэг буюу “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын гишүүдийг чадавхижуулах” зорилгын хүрээнд 2025 оны 4 дүгээр сараас эхлэн тус төсөлтэй хамтран ажиллалаа. Ингэснээр 5 удаагийн зөвлөлдөх уулзалт, зорилтот 3 дүүрэг 2 аймгийн салбар комиссын гишүүдийн чадавхийг сайжруулах уулзалт, сургалтын ажлуудыг хамтран зохион байгууллаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтын гарын авлагыг боловсруулан 250 ширхэгийг хэвлүүлэн үйл ажиллагаандаа ашиглахад бэлэн болголоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын үйлчилгээ, төв болон салбар комиссын үйл ажиллагааг олон нийтэд ойлгуулан таниулах чиглэлээр Өнөөдөр сонинд нийтлэл хэвлүүлэх, видео бичлэг хийлгэх зэрэг ажлуудыг төсөлтэй хамтран зохион байгууллаа. 2025 онд комиссын гишүүдийг чадавхижуулах, эцэг эхчүүдэд	04-12	90%

					зориулсан гарын авлагыг хэвлүүлэх зэрэг ажлуудыг хамтран хийхээр төлөвлөж байна.		
14.	Арга хэмжээ 2.4.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамруулах чиглэлээр төрийн болон Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, шаардлагатай уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан ажиллах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрүүл мэнд, боловсрол нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, хүртээмжтэй болгох чиглэлээр Сайдын 2024 оны 04 сарын 23-ний өдрийн А/85 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж ажлын уулзалтыг 5 удаа зохион байгуулж зөвшилцөн хамтран ажиллалаа. Дээрх зорилгын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: - Нийгмийн халамжийн сангаас олгож буй тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгслийн журмыг шинэчлэх ажлын хэсэгт санал хүргүүлэх - Хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх дэмжих төвийг ажлуулах дүрэм, журмын төслийг боловсруулан батлуулах бэлтгэл ажлыг хангах - Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт"-ийг шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталгаажуулж ажлын хэсгийн эхний хурлыг 2024.11.20-ны өдөр зохион байгууллаа. Мөн Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтран байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалтыг шинэчлэх, Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгож буй тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой байнгын асаргааны хүнд хэлбэрийг тодорхойлох ажлууд хийгдэх юм.	01-12	80%

15.	Арга хэмжээ 2.4.5 Удирдлагаас ирүүлсэн үүрэг даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэн хэрэгжүүлж ажиллах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь			Удирдлагаас ирүүлсэн үүрэг даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэн ажилласан. Жил бүр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ жил “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, нийгэм, эдийн засагт оролцох оролцоо болон бусад тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэх” зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, оролцоо-2024 үндэсний чуулганыг амжилттай зохион байгууллаа. Чуулганд нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төрийн албан хаагчид болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгж байгууллагуудийн 800 орчим төлөөлөл оролцсон. Тус чуулганы үеэр оролцогчдын гарын бэлгийг бэлдэх, урилга бичиж тараах, оролцогчдын ирцийн бүртгэл зэрэг ажлууд болон зохион байгуулалтын ажлуудыг хариуцсан ажилласан.	01-12	90%
Зорилт 3. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
16.	Арга хэмжээ 3.1. Харьяа болон харилцагч байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдолд хариу өгөх, шийдвэрлэх, архивын баримт бичгийг холбогдох журмын дагуу хүлээлгэн өгөх	Хариу өгсөн албан бичгийн тоо			2024 оны байдлаар нийт 62 албан бичиг хүлээн авсан бөгөөд үүнээс хариутай 22 албан бичгийг тухай бүр шийдвэрлэн ажилласан байна. Мөн иргэдээс болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн 25 өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэн ажилласан. 2024 оны эхний хагас жилд газар, хэлтсийн бичиг хэргийг хариуцан ажилласан бөгөөд 28 өргөдөл, гомдол, 118 албан бичиг цахим програмд бүртгэгдсэнийг бичиг хэргийн дэвтэрт бүртгэн мэргэжилтнүүдэд цаг тухайд нь хүлээлгэн өгсөн байна.	01-12	100%

17.	Арга хэмжээ 3.2. Холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлж, албан тушаалын тодорхойлолт, чиг үүрэгтэй холбоотой холбогдох мэдээллүүдийг газрын хариуцсан ажилтан, ТЗУГ-т цаг хугацаанд нь хүргүүлэх	Гаргасан мэдээллийн тоо			Журмын дагуу ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зохих байгууллагад мэдүүлж, албан тушаалын тодорхойлолт, чиг үүрэгтэй холбоотой холбогдох мэдээллүүдийг газрын хариуцсан ажилтан, ТЗУГ-т цаг хугацаанд нь хүргүүлсэн	11	100%
-----	--	-------------------------	--	--	---	----	------


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /Биелэлт/	Эхлэх, дуусах хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1 Байгууллагаас зохион байгуулж буй сургалт, олон нийтийн ажилд тухай бүр идэвхитэй хамрагдах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100%	Байгууллагаас зохион байгуулсан нэгдсэн сургалтуудад бүрэн хамрагдсан.	01-12	90%
2.	Арга хэмжээ 2 Салбарын хэмжээний мэдлэг, мэдээллээ байнга нэмэгдүүлэх	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100%	Монгол Улсын Боловсролын Их сургууль, Япон улсын Нагоя их сургуулийн хамтран зохион байгуулсан хүүхдийн оюун ухааны хөгжлийг тодорхойлох "Монгол Танака-Бинэ" сорил авагчийн сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн хамрагдан амжилттай суралцаж сертификат, оюун ухааны сорил авах хэрэглэгдэхүүний хамт авлаа.	01-12	90%

					Цаашид тус хэрэглэгдэхүүнийг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оюуны чадамжийн үнэлгээг хийх боломжтой болсон.		
3	Арга хэмжээ 3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаар зохион байгуулагдах хурал уулзалт, сургалт семинарт чиг үүргийн дагуу тогтмол хамрагдах	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100%	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах II шатны төслийн хүрээнд хамтарсан зохицуулах зөвлөлийн 4,5 дахь удаагийн хурал болон хаалтын семинарт хариуцсан чиг үүргийн хүрээнд тайланг бэлтгэн мэдээлэл хийж оролцлоо. Мөн Японы хүүхдийг ивээх сангийн "Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хүрээнд 5 удаагийн сургалтанд хамрагдсан байна.	01-12	90%

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

.....
(Албан тушаал)

Б.ЯНЖМАА
/...../ 
(Нэр, гарын үсэг)

2024. 12. 10
.....
(Огноо)